

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

Дотоод аудитын нэр: 2020-2021 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит, хяналт шалгалт

Хамрагдсан байгууллага: Улаанбаатар лифт НӨҮГ

Улаанбаатар хот

2022 он

АГУУЛГА

ТАНИЛЦУУЛГА	3
ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ	4
Зорилго	5
Хамрах хүрээ	5
ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР ДҮН	6
Зорилт 1. Засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын талаар	6
Зорилт 2. Санхүүгийн үйл ажиллагааны талаар	10
Зорилт 3. Хөрөнгө оруулалтын талаар	17
Зорилт 4. Худалдан авах ажиллагааны талаар	21
ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ	21
ЗӨВЛӨМЖ	24

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ӨБ	Өргөх байгууламж
СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоо
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
БЗД	Баянзүрх дүүрэг
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
УСНББОУС	Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг дарга
НӨҮГ	Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар
НТГ	Нийслэлийн татварын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УБЗАА	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
НЗСХ	Нийслэлийн замын сангийн хөрөнгө

ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар лифт Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 06 тоот тогтоолоор Улаанбаатар хотын нийтийн зориулалттай орон сууц, барилга байгууламжийн цахилгаан шатны ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах чиглэлээр байгуулагдсан байна.


Нийтийн зориулалттай орон сууц, барилга байгууламжийн цахилгаан шатны ашиглалт, засвар үйлчилгээг хийх чиглэлээр үйл ажиллагааг явуулдаг байна.

Эрхэм зорилгоо “Улаанбаатар хотын нийтийн зориулалттай орон сууц, барилга байгууламжийн лифтийн талаархи бодлогыг хэрэгжүүлэх, орчин үеийн шинэ техник, технологи нэвтрүүлэх, лифтийн ашиглалт, засвар үйлчилгээг гэрээгээр хариуцах, олгогдсон тусгай зөвшөөрлийн хрээнд аж ахуй нэгжийн гэрээний үндсэн дээр лифтийн магадлал, туршилтын ажлыг гүйцэтгэх, улс, орон нутгийн төсвөөр шинэчлэгдэж буй лифтийн зураг төсөв боловсруулах, захиалагчийн хяналт тавих, мэргэжилтэн боловсон хүчин бэлтгэх, сургах зэргээр үйлчилгээний шуурхай байдал, чанар хүртээмжийг дээшлүүлж, иргэд, оршин суугчдын аюулгүй амьдрах нөхцөл, сэтгэл ханамжийг бүрдүүлэхэд оршино”, алсын хараагаа “... хөгжингүй үлс орны жишигт хүрсэн нийслэлийн хэмжээнд барилгын өргөх байгууламж, лифтийн үйлчилгээг бий болгоно” гэж тодорхойлжээ.

Барилга, хот байгуулалтын яамнаас ӨБ (Өргөх байгууламж)-4.1 Лифт,... угсралтын ажил, засвар, техникийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс 5 жилийн хугацаатайгаар тусгай зөвшөөрөл олгогдсон байна.

Нийслэлийн Засаг даргын 2012 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/184 дүгээр захирамжаар тус газрын дүрэм, орон тооны хязгаарыг 55 албан хаагчтайгаар баталсан бөгөөд орон тооны хязгаарт багтаан 18 албан хаагчтайгаар ажилласан байна.

Улаанбаатар лифт Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын бүтцийг харуулбал:



Тус газар нь батлагдсан дүрэмд дараах 5 гол чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгагджээ.
Үүнд:

- Лифтийн ашиглалт засвар үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх, бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх зөвлөмж, аргачлал, удирдамж боловсруулах;
- Газар нь олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд аж ахуй нэгжийн гэрээний үндсэн дээр лифтийн лифтийн магадлал, туршилтын ажлыг Улаанбаатар хотын нийт лифтэнд хэрэгжүүлэх;
- Улс орон нутгийн төсвөөр шинэчлэгдэж буй лифтийн зураг төсөв боловсруулах, захиалагчийн хяналт хийх ажлыг зохион байгуулах;
- Лифтийн ашиглалт үйлчилгээний салбарыг мэргэжилтэй боловсон хүчнээр бэхжүүлэх, тэдний мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, гадаад дотоодын сургалтад хамруулах, ажилтнуудыг байнгын курсээр бэлтгэх, давтан сургах зэрэг боловсон хүчний нэгдсэн бодлого явуулах;
- Газар нь үйлдвэрлэлийн цехийн материаллаг баазыг өргөтгөн, орчин үеийн машин механизм, шинэ техник технологийг нэвтрүүлэн өргөтгөн бэхжүүлж хүчин чадлыг нь бүрэн ашиглаж, лифтийн сэлбэг үйлдвэрлэх, засварлах, угсрах зэргээр аж ахуйн үйл ажиллагаа явуулах.

Улаанбаатар лифт Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар нь Төрийн сан банкны үндсэн үйл ажиллагааны 100200051073, нэмэлт санхүүжилтийн 100200051402, хөрөнгө оруулалтын 100200051314, барьцаа 100200051342 тоот данснудаар бэлэн бус төлбөр тооцоог хийж ирсэн байна.

Бэлэн ба бэлэн бус төлбөр тооцоонд нэгдүгээр гарын үсгийг газрын дарга Б.Батбаатар 2016 оны 10 дугаар 20-ны өдрөөс 2021 оны 02 дугаар 25-ныг дуустал, Д.Ган-Эрдэнэ нь 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс одоог хүртэл, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Гэрэлмаа 2018 оны 06 дугаар сарын 04-ны өдрөөс дотоод аудит, хяналт шалгалтад хамрагдах хугацаанд хөрөнгө, мөнгийг захиран зарцуулжээ.

Ололттой тал:

“UB ENGINEERING” төслийн мэдээллийн сангийн дата бүрдүүлэх, мэдээллийн сан байгуулах 2298 лифтний ерөнхий мэдээллийг оруулсан. Гэрээгээр хариуцан ажилладаг 161 лифтний дэлгэрэнгүй мэдээллийг нэгтгэн оруулсан.

Өмнөх хяналт шалгалтын талаар:

Нийслэлийн Дотоод аудитын албанаас тус газрын 2018 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитаар 5 зөвлөмж хүргүүлснээс 4 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Нийслэл дэх Төрийн аудитын газраас тус газрын 2021 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийн 135,839.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудит, хяналт шалгалтын хамрах хүрээний хязгаарлалт:

Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” захирамжуудаар Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба болон бусад байгууллагаас зохион байгуулсан худалдан авах ажиллагаа.

ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

Аудит хийх үндэслэл, бүрэлдэхүүн

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3 “Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага,

төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна”, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Нийслэлийн Дотоод аудитын алба (НДАА)-ны “Аудит, хяналт шалгалтын 2022 оны төлөвлөгөө”, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн баталсан 2022 оны 05 дугаар удирдамжийн дагуу Улаанбаатар лифт Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын 2020-2021 оны үйл ажиллагаанд 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 14-ний өдрийг хүртэлх хугацаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудит, хяналт шалгалтыг Нийслэлийн Дотоод аудитын албаны Аудит, хяналт шалгалтын хэлтсийн дарга Ч.Гүрбазар мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллаж, ахлах дотоод аудитор /СХШУБ/ Д.Лувсанчимэд багийг ахлан, дотоод аудитор Х.Долгорсүрэн нарын бүрэлдэхүүнтэйгээр гүйцэтгэлээ.

Зорилго

Улаанбаатар лифт Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаа нь төсөв, санхүү, өмч хөрөнгөтэй холбоотой Монгол улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан заавар, журамтай нийцэж буй эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангахад оршино.

ХАМРАХ ХҮРЭЭ

Дотоод аудит, хяналт шалгалтын удирдамжийн зорилгыг хангахад дараах зорилтуудыг хэрэгжүүллээ. Үүнд:

Дотоод аудит:

- Байгууллагын засаглал;
- Эрсдэлийн удирдлага;
- Дотоод хяналтын үйл явцыг үнэлэх.

Хяналт шалгалт:

Санхүүгийн хяналт шалгалтад тус газрын 2020 он, 2021 оны дараах үйл ажиллагааг хамруулан шалгалаа. Үүнд:

- Санхүү, төсөв, өмч, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль, тогтоомж, түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт;
- Худалдан авалттай холбоотой үйл ажиллагаа;
- Байгууллагын дотоод журам, удирдлагын тушаал, бусад байгууллага хувь хүнтэй байгуулсан гэрээ, хэлцэл нь хууль эрх зүйн үндэслэлтэй хийгдсэн эсэх, тэдгээрийн хэрэгжилт;
- Батлагдсан төсөв түүний зарцуулалт, өөрийн орлогын төлөвлөгөө, биелэлтийн байдал;
- Тус байгууллагын бүтэц орон тоо, цалин хөлсний тогтоолт олгосон байдал;
- Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, олж бэлтгэсэн байдал, тооллого, тооцоо бодолт;
- Санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн байдал;
- Төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэгийн зарцуулалт;
- Хөрөнгө оруулалтын ашиглалт, зарцуулалт;
- Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, баримтын бүрдүүлэлт, боловсруулалт, санхүүгийн мэдээ, тайлан гаргалтын байдал;

- Гадаад, дотоодын байгууллага, иргэдээс өгсөн зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалтын байдал;
- Татвар, нийгмийн даатгалын шимтгэл, ногдол ашиг зэрэг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн төвлөрүүлэлтийн байдал;
- Байгууллагын авлага, өр төлбөрийн үүсэн байдал, барагдуулалт, тооцоо нийлсэн актаар баталгаажсан эсэх;
- Байгууллагын нягтлан бодогчийн хууль тогтоомжид заасан үүргийн биелэлтийг хамруулан шалгалаа.

Шалгуур:

Дотоод аудит, хяналт шалгалтад дараах шалгуурыг ашигласан болно. Үүнд:

- Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжууд;
- Төрийн албаны тухай болон түүнд нийцүүлэн гаргасан холбогдох бусад хууль тогтоомж;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Компанийн тухай хууль;
- Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”;
- Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт;
- НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга;
- НББОУС-16 Үндсэн хөрөнгө;
- УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга;
- Сангийн сайдын 2006 оны “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, журам батлах тухай” 388 дугаар тушаал, мөн уг тушаалд “нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 2008 оны 352 дугаар тушаал;
- Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”;
- Дүрэм, журмаар хүлээсэн эрх үүрэг;
- Холбогдох дүрэм, журмууд.

ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР ДҮН

ЗОРИЛТ 1. ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТАЛААР

Байгууллагын засаглалын талаар:

Засаглах удирдлагын талаар

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны 06 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2012 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/184 дугаар захирамжаар батлагдсан дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус газар нь дараах эрх зүйн баримт бичгийн хүрээнд үүсгэн байгуулагдсан байна. Үүнд:

Хүснэгт 1. Улаанбаатар лифт Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагдсан эрх зүйн баримт жагсаалт

№	Огноо	Шийдвэрийн дугаар	Шийдвэр	Агуулга	Шийдвэр
1	2012.01.27	06 тоот	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол	Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар байгуулах тухай	Нэг. Улаанбаатар хотын нийтийн зориулалттай орон сууц, барилга байгууламжийн цахилгаан шатны ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах нийслэлийн өмчит аж ахуйн тооцот үйлдвэрийн газрыг байгуулсугай.
2	2012.03.15	A/84	НЗД-ын захирамж	Улаанбаатар лифт НӨҮГ-ын дүрэм, бүтэц орон тоог батлах тухай	1-т Улаанбаатар хотын нийтийн зориулалттай орон сууц, барилга байгууламжийн цахилгаан шатны талаархи бодлого хэрэгжүүлэх, захиалагчийн хяналт тавих, ашиглалт засвар үйлчилгээг хариуцах Улаанбаатар лифт НӨҮГ-ын дүрмийг нэгдүгээр хавсралт, бүтэц орон тоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3	2012.04.05	9014001068	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ	Хуулийн этгээдийн гэрчилгээ	Хариуцлагын хэлбэр, Улаанбаатарлифт Орон нутгийн өмчит ААТҮГ

Улаанбаатар лифт Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын даргын 2016 оны А/12 дугаар тушаалаар газрын даргын зөвлөлийн ажиллах журмыг баталсан бөгөөд уг журмын 2. "Зөвлөл нь газрын даргад зөвлөх эрхтэйгээр ажиллана" гэсэн заалтын дагуу даргын зөвлөл нь 2020 онд 15 удаа, 2021 онд 12 удаа хуралдан цаг үеийн шинж чанартай асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж, хурлын тэмдэглэл хөтлөн ажилласан байна.

Газрын даргын 2019 оны 04 дүгээр сарын 29-ний А/06 дугаар тушаалаар хөдөлмөрийн дотоод журмыг баталжээ.

Тус газар нь дотооддоо 19 дүрэм, журам боловсруулан мөрдөж ажилладаг байна. Хавсралт-1-д харуулав.

Дунд хугацааны стратеги төлөвлөгөө

Газрын 2021-2024 оны үйл ажиллагааны дунд хугацааны стратеги төлөвлөгөөг даргын 2021 оны 12 дугаар сарын 16-ны А/27 дугаар тушаалаар батлан хэрэгжилтийг тайлагнасан байна.

Хүснэгт 2. Бодлогын зорилтын хэрэгжилт

№	Бодлогын зорилт	Хариуцсан ажил	Биелэлт
1.	Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	1	89%
2.	Улсын Их хурлын болон Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл	5	100%
3.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	1	80%
4.	Нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилт	4	90%
5.	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Тэргүүлэгчдийн тогтоол шийдвэрийн биелэлт	-	-
6.	Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт	42	95%
	Нийт	53	95%

Бүтэц, орон тооны талаар

Нийслэлийн Засаг даргын “Улаанбаатар лифт НӨҮГ-ын... бүтэц, орон тоог батлах тухай” 2012 оны 03 дүгээр сарын 15-ний өдрийн А/184 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралтаар тус газрын бүтэц, орон тооны хязгаарыг 55 албан хаагчтайгаар баталсан байна.

Улаанбаатар лифт Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын даргын “Орон тоо, цалин батлах тухай” 2013 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/02 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар газрын орон тоог 23 байхаар баталжээ.

Газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/27 дугаар “Байгууллагын бүтцийн нэгжийн гүйцэтгэх чиг үүргийг тодорхой болгох тухай” тушаалаар Захиргаа, санхүүгийн хэсэг, Инженер техникийн хэсэг гэсэн зохион байгуулалтын 2 хэсэгтэй байхаар хэсгүүдийн чиг үүргийг тодорхойлсон байна.

Хүснэгт 3. Бүтэц, орон тоо

№	НЗД-ын 2012 оны А/184 дугаар захирамжаар батлагдсан		Газрын даргын 2013 оны А/02 тушаалаар баталсан	2020-2021 онд
	Албан тушаал	Орон тоо	Орон тоо	Ажиллаж байгаа
1	Дарга	1	1	1
2	Ерөнхий инженер	1	1	1
3	Ерөнхий нягтлан бодогч	1	1	1
4	Хүний хөөцийн мэргэжилтэн	1	1	1
5	Тооцооны нягтлан бодогч	2	1	-
6	Нярав	1	-	1
7	Засвар үйлчилгээ хяналтын албаны дарга	-	1	-
8	Засвар үйлчилгээ хяналтын албаны инженер	-	1	-
9	Хяналтын инженер	3	1	3
10	Угсралтын инженер	1	1	-
11	Техникийн бичиг баримтын инженер	1	-	-
12	КИП- автоматикийн инженер	1	1	-
13	Холбооны инженер	1	-	-
14	Электроникийн инженер	1	1	-
15	Орчуулагч / Хятад, солонгос хэлний/	2	1	-
16	Ээлжийн инженер	3	-	-
17	Механик	8	5	5
18	Ахлах механик	-	3	-
19	Засварчин	20	-	-
20	Токарьчин	1	-	-
21	Мотор ороогч	2	-	-
22	Гагнуурчин	1	-	-
23	Жолооч	3	2	2
24	Архив, бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн	-	-	1
25	Механик инженер /Угсралтын инженер/	-	-	1
26	Үйлчлэгч	-	1	1
	Нийт	55	23	18

Дотоод аудит, хяналт шалгалтад хамрагдах хугацаанд батлагдсан төсөвт орон тооны хязгаарыг 18 албан хаагчтай байхаар баталсан бөгөөд батлагдсан бүтэц орон тооны хязгаарт багтаан ажилласан байна.

Тус газар нь 2020-2021 оны байдлаар инженер техникийн ажилтан 10 буюу 55.5 хувь, захиргааны болон бусад ажилтан 8 буюу 44.4 хувийг эзэлж байна. Үүнээс мэргэжсэн инженер 1 албан тушаалтан ажилладаг байна.

Албан тушаалын тодорхойлолт

Газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/22 дугаар тушаал, 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/08 дугаар тушаалаар нийт 11 албан тушаалын “Албан тушаалын тодорхойлолт”-ыг боловсруулж, баталсан байна.

Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн талаар:

Тус газрын хүний нөөцийн 2021-2024 оны хөгжлийн хөтөлбөрийг газрын даргын 2021 оны А/10 тушаалаар батлан, тайлант онуудын хэрэгжилтийг тайлагнажээ.

Хүний нөөцийн хөдлөлийн талаар:

Тус газрын хэмжээнд 2020 оны байдлаар албан тушаалаас чөлөөлөгдсөн 3, томилогдсон 4, хүүхэд асрах чөлөөтэй 2 албан хаагч, 2021 оны байдлаар албан тушаалаас чөлөөлөгдсөн 10, томилогдсон 9 албан хаагч байна.

Тушаал шийдвэрийн талаар:

Тус газрын дарга нь 2020 онд А тушаал 27, Б тушаал 15, нийт 42 тушаал, 2021 онд А тушаал 35, Б тушаал 26, нийт тушаал 61 тушаал шийдвэр гаргасан байна.

Дүрмээр хүлээсэн чиг үүргийн талаар:

Газрын дүрмээр хүлээсэн лифтийн ашиглалт, засвар үйлчилгээ, техникийн үйлчилгээ, техникийн ээлжит магадлал, улс орон нутгийн төсвөөр шинэчлэгдэж байгаа лифтийн (зураг төсөв боловсруулах), захиалагчийн хяналт хийх болон лифтийн ашиглалт үйлчилгээний салбарыг мэргэжилтэй боловсон хүчнээр бэхжүүлэх тэдний мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, байнгын курсээр бэлтгэх давтан сургах чиг үүрэгтэйгээр ажилладаг. Үүнд:

- Засвар, техник үйлчилгээний чиг үүргийн хүрээнд 2020 онд гэрээгээр хамтран ажилладаг 59 аж ахуйн нэгж, СӨХ-ны (Сууц өмчлөгчдийн холбоо) нийт 1800 (давхардсан тоогоор), 2021 онд гэрээгээр хамтран ажилладаг 61 аж ахуйн нэгж, Сууц өмчлөгчдийн холбооны нийт 1867 (давхардсан тоогоор) лифтэнд засвар, техник үйлчилгээг графикийн дагуу хийж гүйцэтгэн лифтний хэвийн ажиллагааг ханган ажилладаг байна
- Техникийн ээлжит магадлал, туршилтын ажлыг хэрэгжүүлэх хүрээнд 2020 онд гэрээгээр хамтран ажилладаг 31 аж ахуйн нэгж, СӨХ-ны 111 лифт, 2021 онд гэрээгээр хамтран ажилладаг 61 аж ахуйн нэгж, СӨХ-ны 175 лифтэнд техникийн ээлжит магадлалыг хийжээ.
- Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд 16 лифт, 2021 онд 15 шинэчлэгдэж буй лифтэнд захиалагчийн хяналт тавьж ажилласан байна.

Хүснэгт 4. Захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй лифтний тоо

№	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	2020 он	2021 он
		Лифтний тоо	
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	13	
2	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	1	
3	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт	2	15
Нийт		16	15

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн талаар

Улаанбаатар лифт Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын 2012 онд батлагдсан дүрмийн 1.1 “Улаанбаатар хотын нийтийн зориулалттай орон сууц, барилга байгууламжид ашиглагдаж байгаа болон ашиглалтад орох лифтийн туршилт,

тохируулга, магадлал, хяналтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий” гэж тодорхойлсон бөгөөд Барилга, хот байгуулалтын яамнаас Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хуулийн дагуу ӨБ-4.1 “Лифт...угсралтын ажил, засвар, техникийн үйлчилгээ” гэсэн ажил үйлчилгээний төрлөөр тусгай зөвшөөрлийг 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс таван жилийн хугацаатай олгогдсон байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар:

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга болон Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тухайн байгууллагад хамаарах заалтууд, байгууллагын үйл ажиллагааны болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2020 он, 2021 оны биелэлтийн явц, үр дүнг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн байна.

Улаанбаатар лифт Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/11 тушаалаар тус газрын дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмыг баталсан бөгөөд 2017 онд өөрчлөлт оруулсан байна.

Тус газрын даргын 2021 оны А/35 тушаалаар байгуулагдсан дотоод хяналт шалгалт хариуцсан ажлын хэсэг нь ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг тайлагнасан байна.

Шалгалтын явцад хийгдсэн ажлын талаар:

Дотоод аудит, хяналт шалгалтын баг тус газрын захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн лифтний ашиглалтын байдалтай газар дээр нь түүвэрчилсэн хяналтыг хийсэн.

ЗОРИЛТ 2. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Санхүүгийн тайлангийн талаар:

Улаанбаатар лифт Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын 2021 оны санхүүгийн байдлын тайланд нийт хөрөнгийн дүнг 2020 онтой харьцуулахад 78,613.4 мянган төгрөг буюу 27.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 5. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2020 он			2021 он	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /3-2/	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /5-3/
1	2	3	4	5	6
Мөнгөн хөрөнгө	108,712.8	124,968.6	16,255.8	58,175.1	(66,793.5)
Авлага	1,980.0	5,310.0	3,330.0	4,121.6	(1,188.4)
Бараа материал	56,489.5	33,153.1	(23,336.4)	36,788.5	3,635.4
Үндсэн хөрөнгө	115,195.1	98,556.8	(16,638.3)	84,289.8	(14,267.0)
Биет бус хөрөнгө	15,833.8	15,833.8	-	15,833.8	-
Нийт хөрөнгө	298,211.4	277,822.3	(20,389.1)	199,208.8	(78,613.4)
Өр төлбөр	84,824.5	124,968.6	40,144.0	58,175.1	(66,793.5)
Засгийн газрын оруулсан капитал	69,938.3	69,938.3	-	69,938.3	-
Хуримтлагдсан үр дүн	108,108.4	47,575.2	(60,533.2)	35,755.2	(11,819.9)
Дахин үнэлгээний зөрүү	35,340.2	35,340.2	-	35,340.2	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө, эздийн өмчийн дүн	298,211.4	277,822.3	(20,389.1)	199,208.8	(78,613.4)

Тайлант онд нягтлан бодох бүртгэлийн Acolous програмыг ашиглаж бүртгэлийг хөтөлдөг байна. Газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/34 тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталжээ.

Мөнгөн хөрөнгийн талаар:

Тус газрын 2020 оны мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 108,712.8 мянга, 2021 оны эцсийн үлдэгдэл 58,175.1 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна.

Хүснэгт 6.

Мөнгөн хөрөнгө, дансны үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Харилцагчийн нэр	2020 он				2021 он		
	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
Фүшили Элеватор ХХК	-	4,266.5	-	4,266.5	-	4,266.5	-
Оакс экспресс Монголиа ХХК	70,062.6	8,683.5	-	78,746.1	47,032.1	78,746.1	47,032.0
Хан хөгшин трейдинг ХХК	-	3,752.8	-	3,752.8	-	-	3,752.8
Төвхөн трейд ХХК	38,650.2	23,516.8	23,963.8	38,203.2	-	38,203.2	-
Эс Ар трейд ХХК	-	-	-	-	494.7	-	494.7
Арвада ХХК	-	-	-	-	6,895.6	-	6,895.6
Нийт	108,712.8	40,219.6	23,963.8	124,968.6	54,422.4	121,215.9	58,175.1

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 58,175.1 мянган төгрөг болж буурсан нь гэрээний дагуу 5.0 хувийн барьцаа хөрөнгийг чөлөөлснөөс шалтгаалжээ.

Авлагын талаар:

Тус газрын 2020 оны авлага дансны эхний үлдэгдэл 1,980.0 мянга, 2021 оны эцсийн үлдэгдэл 4,121.6 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна. Хавсралт 1-т харуулав.

Хүснэгт 7.

Авлага /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2020 он				2021 он		
	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Төлбөртэй үйлчилгээний авлага	1,980.0	141,739.8	138,409.8	5,310.0	127,936.6	129,231.6	4,015.0
НД-ын байгууллагаас авах авлага				-	106.6		106.6
Нийт	1,980.0	141,739.8	138,409.8	5,310.0	128,043.2	129,231.6	4,121.6

Авлага дансанд 2021 оны жилийн эцэст төлбөртэй үйлчилгээтэй холбоотой 4,015.0 мянга, нийгмийн даатгалын байгууллагаас авах авлага 106.6 мянга, нийт 4,121.6 мянган төгрөгийн авлагатай байна. Үүнийг харилцагч байгууллагаар харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 8.

Төлбөрт үйлчилгээний 2021 оны авлагын үлдэгдлийн задаргаа /мянган төгрөгөөр/

Харилцагчийн нэр	2020 оны эцсийн үлдэгдэл	Нэмэгдсэн	2021 оны эцсийн үлдэгдэл	Тайлбар
Кремль СӨХ	690.0	535.0	1,225.0	Төлөгдөж байгаа.
Сенатор-60 СӨХ	320.0	480.0	800.0	2020 оноос үүссэн авлага СӨХ-ийн дарга төлөхийг хүлээн зөвшөөрсөн.
Бэрс 2 СӨХ	180.0	240.0	420.0	2022 оны 1-р улиралд авлага барагдуулсан.

Төгөл 55 СӨХ	120.0	360.0	480.0	2022 оны 1-р улиралд авлага барагдуулсан.
Тэнгэрлэг 16 СӨХ		100.0	100.0	2022 оны 1-р улиралд авлага барагдуулсан.
Цогчандмана СӨХ	430.0		430.0	2019 оноос үүссэн СӨХ -ийн дарга солигдсон шалтгаанаар төлөхгүй байгаа.
Эрхи-ийн хөршүүд СӨХ		560.0	560.0	2022 оны 1-р улиралд авлага барагдуулсан.
Нийт	1,740.0	2,275.0	4,015.0	

Өглөгийн талаар:

Тус газрын 2020 оны өглөг дансны эхний үлдэгдэл 84,824.5 мянга, 2021 оны эцсийн үлдэгдэл 58,175.1 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан бөгөөд 4 байгууллагаас хөрөнгө оруулалтын ажлын барьцааг суутгасан өр төлбөр байна.

Хүснэгт 9. Барьцаа / мянган төгрөгөөр/

№	Харилцагч	Барьцаа
1	Оакс экспресс Монголиа ХХК	47,032.0
2	Хан хөгшин трейдинг ХХК	3,752.8
3	Эс Ар трейд ХХК	494.7
4	Арвада ХХК	6,895.6
Нийт		58,175.1

Бараа материалын талаар:

Тайлант 2020 онд 10,242.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 33,048.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 530.0 мянган төгрөгийн бараа материалыг акталж, 33,153.1 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэл тайлагнасан байна.

Улаанбаатар лифт Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн А/25 дугаар тушаалаар 2 нэр төрлийн 5ш, 530.0 мянган төгрөгийн бараа материалыг актлаж данс бүртгэлээс хасжээ.

Тайлант 2021 онд 105,600.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 101,559.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 406.0 мянган төгрөгийн бараа материалыг акталж, 36,788.5 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэл тайлагнасан байна.

Тус газрын даргын 2021 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн А/17 тушаалаар 5 нэр төрлийн 8ш, 406.0 мянган төгрөгийн бараа материалыг актлаж данс бүртгэлээс хасжээ.

Хүснэгт 10. Бараа материалын тайлан /мянган төгрөгөөр/

№	Дансны нэр	2020 он				2021 он		
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Бичиг хэргийн материал	76.1	800.0	781.5	94.5	1,109.9	1,068.1	136.4
2	Аж ахуйн материал	150.3	2,581.0	2,336.5	394.8	5,251.0	5,176.3	469.5
3	Сэлбэг хэрэгсэл	53,972.0		25,148.0	28,824.0	79,360.0	86,530.5	21,653.5
4	Түлш, шатах тослох материал	158.2	4,385.1	4,397.5	145.8	4,978.3	4,958.0	166.2
5	Бусад хангамжийн материал	2,132.9	2,476.0	915.0	3,693.9	14,901.5	4,232.5	14,362.9
	Нийт дүн	56,489.5	10,242.1	33,578.5	33,153.1	105,600.7	101,965.3	36,788.5

Сөрт ХХК-аас 2021 онд 26 нэр төрлийн 79,360.0 мянган төгрөгийн лифтний засварын сэлбэг хэрэгслийг худалдан авч зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгийн талаар:

Тайлант 2020 онд үндсэн хөрөнгө дансанд 247,021.0 мянган төгрөгийн эхний үлдэгдэл тайлагнаж, 760.0 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 2,964.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 17,281.2 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл байгуулж 244,816.3 мянган төгрөгийн үлдэгдлийг тайлагнасан.

Бусад биет бус хөрөнгөнд Баянзүрх дүүргийн (БЗД)-ийн 15 дугаар хороонд байрлах 489 м кв газар бүртгэлтэй байна.

Хүснэгт 11. Үндсэн хөрөнгийн тайлан /мянган төгрөгөөр/

Дансны нэр	2020 он					2021 он			
	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	ТҮ Элэгдлийн зардал	Эцсийн үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	ТҮ Элэгдлийн зардал	Эцсийн үлдэгдэл
Барилга байгууламж	79,771.1	-	-	2,045.4	79,771.1	-	-	2,045.4	79,771.1
Авто тээврийн хэрэгсэл	108,200.0	-	-	10,820.0	108,200.0	-	-	10,820.0	108,200.0
Тоног төхөөрөмж	33,023.4	760.0	2,584.7	3,552.5	31,198.7	-	-	576.4	31,198.7
Тавилга хэрэгсэл	8,918.7	-	380.0	863.3	8,537.7	-	-	825.1	8,537.7
Програм хангамж	1,275.0	-	-	-	1,275.0	-	-	-	1,275.0
Бусад биет бус хөрөнгө	15,833.8	-	-	-	15,833.8	-	-	-	15,833.8
Нийт дүн	247,021.0	760.0	2,964.7	17,281.2	244,816.3	-	-	14,266.9	244,816.3

Тайлант 2021 онд нэмэгдсэн, хасагдсан хөрөнгө байхгүй байна. Тайлант 2021 онд үндсэн хөрөнгө дансанд 244,816.3 мянган төгрөгийн эхний үлдэгдэл тайлагнаж, 14,266.9 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл байгуулж тайлант оны эцэст үлдэгдлийн дүнд өөрчлөлт ороогүй байна.

Газрын даргын 2020 оны 06 дугаар сарын 23-ний өдрийн А/11, 2020 оны 12 дугаар сарын 07-ний өдрийн А/20, 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/14, 2021 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн А/30 дугаар тушаалуудаар байгуулагдсан тооллогын комисс нь эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулсан байна.

Санхүүжилтийн талаар:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 06/6262 дугаар албан тоот, 2020 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн 06/6872 дугаартай албан бичгээр Улаанбаатар лифт Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын 2020 он, 2021 оны батлагдсан төсвийг ирүүлсэн байна.

Тус газар нь 2020 онд орон нутгийн төсвөөс санхүүжилт 115,990.4 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 130,000.0 мянга, нийт 245,990.4 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас, орон нутгийн төсвөөс 115,990.4 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 134,143.3 мянга, хөрөнгийн санхүүжилт 1,005,535.7 мянга, нэмэлт санхүүжилтээр 85,331.7 мянга, нийт 1,341,001.1 мянган төгрөгийн орлого тайлагнасан байна.

Тус газар нь 2021 онд орон нутгийн төсвөөс санхүүжилт 116,787.5 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 130,000.0 мянга, нийт 246,787.5 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас, орон нутгийн төсвөөс 116,441.5 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 129,231.6 мянга, хөрөнгийн санхүүжилт 768,188.5 мянга, нэмэлт санхүүжилтээр 126,556.3 мянга, нийт 1,140,417.9 мянган төгрөгийн орлого тайлагнасан байна.

Хүснэгт 12. Санхүүжилтийн эх үүсвэр /мянган төгрөгөөр/

Эх үүсвэр		2020 он			2021 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Эзлэх хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Эзлэх хувь
Орон нутгийн төсвийн санхүүжилт /урсгал үйл ажиллагааны санхүүжилт/		115,990.4	115,990.4		116,787.5	116,441.5	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		130,000.0	134,143.3		130,000.0	129,231.6	
Санхүүжилт		245,990.4	250,133.7		246,787.5	245,673.1	
Хөрөнгийн			1,005,535.7			768,188.5	
Санхүүжилт, хөрөнгийн нийт дүн			1,255,669.4			1,013,861.6	
Нэмэлт санхүүжилт	ЗГ-ын нөөц хөрөнгө, ЗД-ын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах нөөц хөрөнгөөс		85,331.7				
	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө					126,556.3	
	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого						
Нэмэлт санхүүжилтийн дүн							
Нийт дүн		245,990.4	1,341,001.1		246,787.5	1,140,417.9	

Үндсэн үйл ажиллагааны орлого:

Тус газар нь чиг үүргийн хүрээнд техникийн үйлчилгээг хийх, техникийн ээлжит магадлагаа хийх, лифтчиний сургалт хийх чиглэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрдүүлдэг байна. Тухайлбал:

- Аж ахуйн нэгж, СӨХ-ны лифтэнд техник үйлчилгээ хийж техник үйлчилгээг хийх;
- Гэрээгээр хамтран ажилладаг аж ахуйн нэгж, СӨХ-ны лифтэнд техникийн ээлжит магадлалыг хийх;
- Мэргэжлийн лифтчин бэлтгэж ажлын байраар хангах.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг задлан харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 13. 2020, 2021 оны үндсэн үйл ажиллагааны орлогын задаргаа /мянган төгрөгөөр/

Орлогын үзүүлэлт	2020 он		2021 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих Үүнээс:		134,143.2		129,231.5
Лифтийн магадлал	130,000.0	5,700.0	130,000.0	9,730.0
Лифтийн техник үйлчилгээ		102,770.0		107,845.0
Захиалагчийн хяналт		25,353.2		11,256.5
Лифтчиний сургалт		320.0		400.0

Тус газар нь 2020 онд үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 103.1 хувь буюу 4,143.2 мянган төгрөг байна.

Лифтийн техник, үйлчилгээний орлого 76.6 хувь буюу 102,770.0 мянга, захиалагчийн хяналт 18.9 хувь буюу 25,353.2 мянга, лифтийн магадлал 4.3 хувь буюу 5,700.0 мянга, лифтчиний сургалт 0.2 хувь буюу 320.0 мянга, нийт 134,143.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Тус газар нь 2021 онд үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 768.5 мянган төгрөгөөр тасарч, биелэлт 99.5 хувьтай байна. Энэ нь Ковид-19 цар тахлын хөл хориотой холбоотой орлого тасарсан байна.

Лифтийн техник, үйлчилгээний орлого 83.4 хувь буюу 107,845.0 мянга, захиалагчийн хяналт 8.7 хувь буюу 11,256.5 мянга, лифтийн магадлал 7.6 хувь буюу 9,730.0 мянга, лифтчиний сургалт 0.3 хувь буюу 400.0 мянга, нийт 129,231.5 мянган төгрөгийн орлого тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн орлого:

Тус газар нь 2020 онд 85,331.7 мянга, 2021 онд 126,556.3 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Харилцагчаар задлан харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 14. Нэмэлт санхүүжилтийн орлого /мянган төгрөгөөр/

№	Байгууллага	2020 он	2021 он	Утга
1	Төрийн сан	85,331.7		НЗД-ын А/789-р захирамжаар лифтний засварын зардал
2	УБ зам засвар арчлалт ОНӨААТҮГ		107,884.3	Гүүрэн гарцны гэрээт ажил
3	Захирагчийн ажлын алба Төрийн сан		18,672.0	ХУД 1 хороо 120 мянгатын явган хүний гүүрэн гарцны цахилгаан шатанд нэмэлтээр халаагч суурилуулах зардал
Нийт		85,331.7	126,556.3	

Дээрх нэмэлт санхүүжилтийн орлого нь дараах захирамжуудад үндэслэжээ.

Үүнд: Нийслэлийн Засаг даргын 2020 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/789 захирамжаар Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэх Баянгол дүүргийн нутаг дэвсгэр дэх зарим орон сууцуудын ажиллах боломжгүй зогссон цахилгаан шатны сэлбэг нийлүүлэх 85,734.0 төсөвт өртөгтэй ажлын худалдан авах ажиллагааны эрхийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд, захиалагчийн хяналтыг тус газарт даалгасан;

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/209 захирамжаар нийслэлийн замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх 135,499.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй Гүүр хоолой, тунелийн засварын ажлыг 4 дүгээр хавсралтаар баталсан;

Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн албаны даргын 2021 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн “Хөрөнгө гаргах тухай” А/333 дугаар тушаалаар 18,872.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороо, 120 мянгатын явган хүний гүүрэн гарцны цахилгаан шатанд нэмэлтээр халаагч суурилуулж, ажиллуулах зардлыг Хотын гэрэлтүүлгийн урсгал зардлын хэмнэлтээс санхүүлэн уг асуудлыг дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд Улаанбаатар лифт НӨҮГ-аар гэрээгээр гүйцэтгүүлэхийг даалгасан байна.

Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Тус газар нь 2020 онд орон нутгийн төсвөөс санхүүжилт 115,990.4 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 130,000.0 мянга, нийт 245,990.4 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас, гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 115,990.4 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 134,143.3 мянга, нийт 248,058.9 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

